

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монголын төмөр зам ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн
тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/76/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Д.Эрдэнэчимэг
Утас 263533 Цахим хаяг: erdenechimegda@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас: 70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ОТГОНСҮХ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/718
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монголын төмөр зам ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 22,830.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.Тухайлбал:

- Гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй байхад 5 төсөл арга хэмжээний 2,456.0 сая төгрөгийн гэрээ хийсэн, 3,962.7 сая төгрөгийн 1 оролцогчийн гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулснаас хойш гаргуулан авсан;
- Тайлант оны эцсийн байдлаар 39 харилцагчтай холбоотой 2,931.3 сая төгрөгийн авлага, 52 харилцагчтай холбоотой 6,791.2 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 43 дугаар зүйлийн 43.1, 44.1 дахь заалтуудтай нийцэхгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монголын төмөр зам ТӨХК нь Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтын төмөр замын

Z:\Yawsan_Bichig\2024\0325 SNAG-44.Docx

0001051016

төслийн барилгын ажлыг 2023 онд эхлүүлж, Шивээ хүрэн боомтын хил дамнасан нарийн царигийн төмөр замыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Үндэсний төмөр замын сүлжээг 2023 онд 416.1 километрээр өргөтгөж, 8 дугаар сард Тавантолгой Зүүн-Баян чиглэлийн төмөр замыг улсын комисс байнгын ашиглалтад хүлээж авсан байна. Тус төмөр зам нь 1 өртөө 6 зөрлөгтэй жилд 15 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай байна. Өмнөх онд Монголын төмөр зам ТӨХК-ийн орлогын 67.2 хувийг түрээсийн орлого эзэлж байсан бол тайлант онд ачаа, тээвэрлэлтийн хэмжээг 2.5 дахин өсгөж 1.8 сая.тн-д хүргэж, нийт орлогын 88.3 хувийг ачаа тээврийн орлого эзэлж байгаа нь компанийн тээврийн үйл ажиллагааг жигдрүүлэх эхлэл тавигдсан байна гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Монголын төмөр зам ТӨХК нь 2023 онд 7 зорилтын хүрээнд 51 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 90.0 хувийн гүйцэтгэлтэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулалт дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8,193,365,242.94	41,320,277,023.12
1.1.2	Дансны авлага	15,633,693,479.97	31,753,857,995.64
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	41,056,139,158.09	36,683,827,715.54
1.1.4	Бусад авлага	57,127,237.00	67,973,823,538.08
1.1.6	Бараа материал	49,594,579,742.27	9,463,033,715.47
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	91,871,430,848.33	29,051,364,443.62
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	2,611,870,635.56
	Эргэлтийн хөрөнгийн дүн	206,406,335,708.60	218,858,055,067.03
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,459,298,458,323.7	238,604,915,229.31
1.2.2	Биет бус хөрөнгө	13,453,449,069.92	13,487,982,577.45
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	693,767,529,201.48	693,765,710,701.48
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	5,800,274,294.31	6,132,487,137.24
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	6,894,283,171.78	11,706,564.64
1.2.9	Дуусаагүй барилга	-	1,291,500,239,582.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,179,213,994,061.24	2,243,503,041,792.18
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,385,620,329,769.84	2,462,361,096,859.21
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	24,890,809,383.88	23,689,493,967.14
2.1.1.2	Цалингийн өглөг	24,383,677.00	-
2.1.1.3	Татварын өр	580,942,839.37	48,943,292,597.10
2.1.1.4	НДШ–ийн өглөг	120,924,908.39	8,998.95
2.1.1.6	Хүүний өглөг	-	5,432,339,209.65
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,777,937,026.94	6,200,229,210.14
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	51,280,855,627.88	51,294,628,619.10
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	83,675,853,463.46	135,559,992,602.08
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	337,064,612,752.94	333,753,143,895.09
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	642,540,904.47	1,753,978,930.39
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	1,273,405,301,440.0	1,336,123,253,693.0
2.1.2.5			
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,611,112,455,097.4	1,671,630,376,518.4
2.2	Өр төлбөрийн нийт дүн	1,694,788,308,560.8	1,807,190,369,120.5
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	20,727,658,514.60	20,727,658,514.60
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	139,351,735.55	139,351,735.55
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	768,206,030,794.14	768,206,030,794.14
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(98,241,019,835.32)	(133,902,313,305.64)
2.3.11	Эздийн өмчийн дүн	690,832,021,208.97	655,170,727,738.65
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,385,620,329,769.84	2,462,361,096,859.21

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	25,420,923,224.29	67,849,134,181.34
2	Борлуулалтын өртөг	17,283,351,741.83	40,028,707,162.68
3	Нийт ашиг(алдагдал)	8,137,571,482.46	27,820,427,018.66
4	Түрээсийн орлого	44,513,717,820.55	-
5	Хүүгийн орлого	-	771,919,583.83
8	Бусад орлого	-	51,054,518.70
10	Ерөнхий ба удирдлагын зардал	37,542,249,604.65	11,004,021,009.77
11	Санхүүгийн зардал	5,265,062,770.59	5,772,899,484.94
12	Бусад зардал	-	869,727,242.76
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(58,594,914,902.88)	3,376,072,087.50
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	(29,798,996.26)
17	Бусад ашиг (алдагдал)	(664,754.28)	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(48,751,602,729.39)	14,343,026,474.96
19	Орлогын татварын зардал	(5,016,413,593.43)	1,438,685,497.11
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(43,735,189,135.96)	12,904,340,977.85
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(43,735,189,135.96)	12,904,340,977.85
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(43,735,189,135.96)	12,904,340,977.85
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	767,576,523,667.88	(52,817,742,960.07)	735,625,790,957.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,577,687,739.29)	(1,577,687,739.29)
Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	767,576,523,667.88	(54,395,430,699.36)	734,048,103,218.67
Өмчид гарсан өөрчлөлт			629,507,126.26		629,507,126.26
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(43,735,189,135.96)	(43,735,189,135.96)
Зарласан ногдол ашиг				110,400,000.00	110,400,000.00
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(98,241,019,835.32)	690,832,021,208.97
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(48,565,634,448.17)	(48,565,634,448.17)
Залруулсан үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(146,806,654,283.49)	642,266,386,760.80
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				12,904,340,977.85	12,904,340,977.85
2023 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	20,727,658,514.60	139,351,735.55	768,206,030,794.14	(133,902,313,305.64)	655,170,727,738.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	65,649,841,731.18	60,004,373,075.41
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	58,554,774,553.10	56,341,955,953.85
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		28,982,388.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	7,095,067,178.08	3,633,434,733.56
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	69,260,970,264.39	47,263,994,192.95
1.2.1	Ажиллагчдад төлсөн	8,389,194,029.00	17,822,573,505.89
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	2,860,192,957.42	5,065,270,483.52
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	3,943,040,271.01	11,331,966,227.50
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	71,106,294.53	2,077,531,289.58
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	176,934,698.15	4,640,285,640.86
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	5,318,521,178.67	218,152,345.55
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	1,054,713,975.39	2,404,809,267.41
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		35,409,590.61
1.2.9	Бусад мөнгөн зарлага	47,447,266,860.22	3,667,995,842.03
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(3,611,128,533.21)	12,740,378,882.46
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	109,435,095,822.88	32,030,257,217.62
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	109,435,095,822.88	31,990,707,817.62
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		39,549,400.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(109,435,095,822.88)	(32,030,257,217.62)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	120,128,308,237.39	52,430,005,809.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	120,000,000,000.00	52,430,005,809.00
3.1.4		128,308,237.39	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	273,921,879.98	13,240,831.11
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		13,240,831.11
3.2.4	Төлсөн ногдол ашиг	110,400,000.00	
3.2.5		163,521,879.98	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	119,854,386,357.41	52,416,764,977.89
4	Валютын ханшийн зөрүү		25,137.45
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	6,808,162,001.32	33,126,911,780.18
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,385,203,241.62	8,193,365,242.94
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,193,365,242.94	41,320,277,023.12

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он		Өсөлт, бууралт (+/-)	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ОРЛОГО	69,934.6	79,582.3	68,672.1	(10,910.2)	(14.0)
1.1	Хөдлөх бүрэлдэхүүн, бусад түрээс	19,661.7	278.0	3,103.2	2,825.1	1,116.3
1.2	Төмөртэй тээвэр	2,339.4	1,315.2	1,704.2	389.0	30.0
1.3	Зам анги	-	116.7	324.8	208.2	278.3
1.4	Цогтцэций тээвэр	20,602.7	73,733.8	58,624.3	(15,109.4)	(20.0)
1.5	ШАЦ,Замын-үүд/	27,330.9	4,138.7	4,092.6	(46.0)	(1.0)
1.6	Төвлөрүүлсэн орлого	-	-	823.0	823.0	
2	НИЙТ ЗАРДАЛ	118,686.2	79,165.3	57,675.4	(21,549.5)	(27.0)
2.2	Үүнээс: Ерөнхий удирдлагын зардал	42,807.9	2,896.6	11,004.0	8,107.4	(279.9)
2.3	Ханшийн зөрүүний ашиг /алдагдал/	(58,594.9)	-	3,376.1	3,376.1	
2.4	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-	(29.8)	(29.8)	
3	Татварын өмнөх ашиг /алдагдал/	(48,751.6)	417.0	14,343.0	13,926.0	3439.5
4	Орлогын албан татвар	5,016.4	41.7	1,438.7	1,108.4	336.0
8	Цэвэр ашиг (алдагдал)	(43,735.2)	375.3	12,904.3	12,817.6	3438.4
5	Төрийн өмчийн ногдол ашиг	-	207.3	207.3	-	0.0
6	Нийт ажиллагсдын тоо	669	669	550	119	0.0
7	Нийт цалингийн сан	12,673.5	21,176.8	21,043.2	(133.6)	(1.0)
8	Нэг ажилтны дундаж цалин	1.9	3.2	3.2	(0.0)	(0.0)
9	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	0,86	0.99	0.83	-0.16	(16.2)
10	Хөрөнгө оруулалт	6,683.1	13,616.9	654.6	(12,962.3)	4.8
11	Нийт авлага	56,740.4	10,809.5	99,727.6	88,918.1	922.5
11.1	Үүнээс: Найдваргүй	-	-	-	-	
12	Нийт өглөг	1,694,145.8	1,678,655.0	1,807,190.4	128,535.4	7.6
12.1	Богино хугацаат өр төлбөр	83,675.9	83,581.6	135,560.0	51,978.4	62.1
12.2	Урт хугацаат өр төлбөр	1,610,469.9	1,595,073.4	1,671,630.4	76,557.0	4.7

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 150,822.6 сая төгрөгийн 11 алдаа¹ илэрснээс аудитын явцад 150,658.3 сая төгрөгийн 9 алдааг залруулж, 164.3 сая төгрөгийн 2 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн ангилалд дуусаагүй барилгын өртөгт шингээн бүртгэх 1,291.5 сая төгрөгийг бараа материалын ангилалд тайлагнасан	1	1,291.5			1	1,291.5	1	1,291.5				
Авлагын дансанд тайлагнах 67,119.0 сая төгрөгийн 4 жилийн насжилттай авлагыг урьдчилж төлсөн тооцоо дансанд дансанд тайлагнасныг аудитаар залруулж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулуулсан	1	67,119.0			1	67,119.0	1	67,119.0				
Татварын хяналт шалгалтаар тогтоогдсон 4,219.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгийн албан татвар, торгууль, алданги, 43,550.6 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар, хүү, алдангийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрөөгүй, санхүүгийн тайланд тусгаагүй	1	47,770.4	1	47,770.4			1	47,770.4				
Монголын төмөр зам ТӨХК нь Монголиан транс лайн ХХК-ийн 4,142.2 сая төгрөгийн орлогыг бууруулсан байгааг хянахад 2023 оны 04-р сарын 28-ний өдрийн СБАГ-2023/02 АГ/23-26 тоот гэрээний дагуу суурь бүтэц ашигласан нөхцөлд тээвэрлэсэн ачааны хэмжээг цэвэр жин /чингэлэгийн хувийн жинг оруулж тооцсон/-гээр тооцно гэснийг зөрчиж Монголын төмөр зам ТӨХК-ийн нэхэжлэлд зүтгүүрийн жинг оруулж тооцон 2,638.7 сая төгрөгийн тооцооллыг нэмж нэхэмжилсэн байна гэж үзэж алдаагаар авсан ба зөрүү 1503.5 сая төгрөгийн орлогыг тайлант онд залруулан бүртгүүлсэн.	1	1,503.5	1	1,503.5			1	1,503.5				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Өмнөх тайлант хугацааны зардалд хамаарах 19.7 сая төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант оны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн	1	19.7	1	19.7			1	19.7				
Тус компани нь охин компаниудын санхүүгийн тайланг толгой компанийн санхүүгийн тайлантай нэгтгээгүй, нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэн, толилуулаагүй	1		1				1					
Шүүхийн шийдвэрийн дагуу данснаас хасах 4 харилцагчтай холбоотой 365.4 сая төгрөгийн авлагыг данснаас хасаагүй	1	365.4	1	365.4			1	365.4				
Аудитын түүвэр тооллогоор үүссэн зөрүүтэй холбоотойгоор 1,659.2 сая төгрөгийн бараа материалыг комисс томилон тооллогод хамруулан, өмнөх онуудад зарцуулагдсан, анхан шатны баримттай зардалд тусгаагүй байсан 417.6 сая төгрөгийн бараа материалыг хяналтын алба болон ТУЗ-д танилцуулж, зөвшөөрсний дагуу алдааны залруулгаар хуримтлагдсан ашиг дансанд бүртгэсэн, биетээр оршин байхгүй байгаа 443.6 сая төгрөгийн хөрөнгийг хууль хяналын байгууллагад өгч шийдвэрлүүлэх мөн 696.7 сая төгрөгийн барааг өөр байршлаас олж хариуцсан няравт хүлээлгэн өгсөн, 101.3 сая төгрөгийн бараа материалыг 2023 онд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэн залруулсан.	1	1,659.2			1	1,659.2	1	1,659.2				
Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгөн хөрөнгийн ангилалд тайлагнах 30,929.6 сая төгрөгийг бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгөн хөрөнгийн ангилалд тайлагнасан	1	30,929.6			1	30,929.6	1	30,929.6				
Санхүүгийн тайланд 139.4 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл тусгагдсан байхад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд тусгагдаагүй буюу аль хөрөнгөд хамаарах нь тодорхойгүй байна.	1	139.4	1	139.4					1	139.4	1	139.4
Үндсэн хөрөнгийн биет бус хөрөнгийн ангилалд бараа материалын шинж чанартай 2 ш 24.9 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	24.9			1	24.9			1	24.9	1	24.9
Дүн	11	150,822.6	6	49,798.4	5	101,024.2	9	150,658.3	2	164.3	2	164.3

Аудитаар нийт 22,830.3 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 8.4 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 22,038.0 сая зөрчилд төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 783.9 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хуулийн байгууллагад шилжүүлэх	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх аудитаар өгсөн "БНХАУ-аас авсан дамжуулан зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлөгдөж байгааг шалгахад Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх төсөл, Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх төсөл, Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төслийн БНХАУ-ын Экспорт-импорт банкаас авсан дамжуулан зээлийн үндсэн өр 279,623.0 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөр 5,014.1 сая төгрөг, ханшийн зөрүүгийн алдагдалд 57,441.6 сая төгрөг үүссэн тул дээд шатны байгууллагад хандан зээлийн эргэн төлөлтийн чадварыг дахин хянуулах" зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1				1							
Тайлант онд тус компани үр ашиггүй, алдагдалтай ажилласан байхад ажилтануудад үйл ажиллагааны үр дүнгийн урамшуулалт цалинг 100 хувиар тооцож 525.3 сая төгрөг олгосон. Ажилтнуудад 5-12 дугаар сард хээрийн нэмэгдэл цалинг олгохдоо эрх зүйн байдал тодорхойгүй байгаагаас шалтгаалан компанийн удирдлага хувь хэмжээг харилцан адилгүй 20-147 хувиар тогтоож 1,801.0 сая төгрөг бодож олгосон. 2.Төслийн нэмэгдэл цалинг 10-12 дугаар сард ажилтнуудад олгохдоо эрх зүйн байдал тодорхойгүй байгаагаас шалтгаалан компанийн удирдлага хувь хэмжээг харилцан адилгүй 24-100 хувиар тогтоож 171.3 сая төгрөг бодож олгосон. 3.Ажлаас хууль бусаар халагдсан 2 ажилтанд ажилгүй байх хугацааны нөхөн олговорт 34.0 сая	1				1							

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төгрөгийг төлж буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй гэсэн албан шаардлага 50 хувийн хэрэгжилттэй гэж үзлээ. 2023 оны аудитаар цалин хөлс, хээрийн нэмэгдэлтэй холбоотой зөрчлүүд дахин давтагдаж гарсан байгаа болно.											
Бүтэц орон тоонд батлагдаагүй албан тушаалд 50 гэрээт ажилтан ажиллуулж 633.2 сая төгрөгийн цалин хөлс олгосон, цалингийн хүснэгтийн зэргийн нэмэгдлийн хэсэгт ур чадвар, зэрэг, нууцын нэмэгдэл, цолны болон хариуцлагын зэрэг олон төрлийн нэмэгдлийг нэгтгэн оруулснаас шалтгаалан нэмэгдэл тус бүрийг тушаалтай тулган шалгах боломжгүй, зэргийн нэмэгдлийг материаллаг дүнгээр илүү олгож байгаагаар цалингийн хүснэгтэд тусгагдсан, ур чадварын нэмэгдэл цалинг хэдэн хувиар олгох, ур чадвартайг хэрхэн үнэлж, тооцох шалгуур үзүүлэлтийг тусгасан журам байхгүй, ажилтанд олгож буй нэмэгдэлийн үндэслэл тодорхой бус байна.	1	633.2					1	633.2			
Ээлжийн амралтын цалинг холбогдох журмын дагуу тооцож байгаа эсэхэд түүвэр шалгалт хийж, 15 ажилтны ээлжийн амралтын олговрыг давтан тооцоход хоол унааны олговрыг дундаж цалин хөлсөд оруулан тооцсоноос 2.1 сая төгрөгийг илүү олгосон. 5-р сарын цалингийн хүснэгтээрх гарт олгох цалинг банк руу илгээсэн гарт олгох цалингийн дүнтэй тулгалт хийхэд 41 ажилтны цалинг 3.2 сая төгрөгөөр илүү олгосон байна. Мөн 1 ажилтны хээрийн нэмэгдэл болох 39 хувийг програмд оруулахдаа 339 хувь гэж алдаатай оруулснаас 6.6 сая төгрөгийн нэмэгдлийг илүү олгосны 3.5 сая төгрөг суутгаж 3.1 сая төгрөг суутгаагүй байна.	1	8.4	1	8.4							
Тайлант онд 238 харилцагчтай холбоотой 148,906.5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээг түүвэрлэн авч цахим төлбөрийн баримттай тулган шалгахад 9 харилцагчтай холбоотой 12.7 сая төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас дутуу гаргуулан авсан байна.	1	12.7					1	12.7			
Тайлант оны эцсийн байдлаар 39 харилцагчтай холбоотой 2,931.3 сая төгрөгийн авлага, 52 харилцагчтай холбоотой 6,791.2 сая төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэл тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна.	1	9,722.5			1	9,722.5					
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа бараа материалын үлдэгдлийг тооцохгүйгээр тайлант оны хэрэгцээг үндэслэн төлөвлөдөг, чанарын шаардлага	1	81.6					1	81.6			

хангахгүй, бараа материал худалдан авсан зэргээс шалтгаалж 17 нэр төрлийн 81.6 сая төгрөгийн насжилт өндөртэй бараа материалын нөөц үүссэн.												
Завсрын аудитаар бараа материалын тооллогоор дутагдсан 443.6 сая төгрөгийн бараа материал, 2019-2022 онд хэрэгжсэн төмөр замын бүтээн байгуулалтын төсөлд ашиглагдаж байсан 770.6 сая төгрөгийн бодитоор байхгүй хөрөнгө бүгд 1,214.2 сая төгрөгийн дутагдлыг хууль хяналтын байгууллагад хүргүүлэх	1	1,214.2			1	1,214.2						
Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланд 56.4 сая төгрөгийн орлогыг дутуу тайлагнаж, 5.6 сая төгрөгийн татварыг дутуу ногдуулсан.	1	56.4					1	56.4				
Тайлант оны авлага, өглөгийн тулган баталгаажуулалтыг хийхэд 2 харирлцагчийн үлдэгдэл 18.8 сая төгрөгөөр дутуу, 2,025.1 сая төгрөгөөр илүү байгаагаар баталгаажуулсан байна.	1	2,043.9			1	2,043.9						
Монголын төмөр зам ТӨХК нь Монголиан транс лайн ХХК-ийн 4,142.2 сая төгрөгийн орлогыг бууруулсан байгааг хянахад 2023 оны 04-р сарын 28-ний өдрийн СБАГ-2023/02 АГ/23-26 тоот гэрээний дагуу суурь бүтэц ашигласан нөхцөлд тээвэрлэсэн ачааны хэмжээг цэвэр жин /чингэлэгийн хувийн жинг оруулж тооцсон/-гээр тооцно гэснийг зөрчиж Монголын төмөр зам ТӨХК-ийн нэхэжлэлд зүтгүүрийн жинг оруулж тооцон 2,638.7 сая төгрөгийн тооцооллыг нэмж нэхэмжилсэн байна.	1	2,638.7			1	2,638.7						
Тус байгууллагын 2023 оны зорилтот түвшини биелэлтийг тооцоход төлөвлөлтийг судалгаагүй, үндэслэл муутай төлөвлөснөөс үйл ажиллагааны үр дүнг хувиар илэрхийлэхэд бодитой бус дүгнэгдэж байна.	1						1					
Худалдан авах ажиллагааны төсөвт өртөг болон гүйцэтгэлээрх өртөг материаллаг зөрүүтэй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа төсөвт өртгийн үнийн судалгаа хийгээгүй, үндэслэлгүй төлөвлөсөн, гүйцэтгэлийн баталгаа шаардах 2,456.0 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй байхад гэрээ хийсэн, 3,962.7 сая төгрөгийн 1 оролцогчийн гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулснаас хойш гаргуулан авсан.	1	6,418.7			1	6,418.7						
Дүн	13	22,830.3	1	8.4	7	22,038.0	5	783.9	0	0.0	0	0.0

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн 28,603.6 сая төгрөгийн зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Өмнөх аудитаар хүргүүлсэн "Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээлж байх" албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тайлант онд Шилэн дансанд хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна. Мөн Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 51 удаагийн 2,769.0 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг шилэн дансанд байршуулаагүй ба 152 удаагийн 81,466.0 сая төгрөгийн орлого, 437 удаагийн 19,540.6 сая төгрөгийн зарлагын мөнгөн гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	28,603.6	1	28,603.6		
Дүн	1	28,603.6	1	28,603.6		